

**Бөөгийн болон Бурхны шашны үзэл Монгол газар нутгийн
нэрэнд туссан нь**

Э. Равдан*

Энэхүү өгүүлэлд бид эртний Бөөгийн болон Бурхны шашны үзэл Монголын газар нутгийн нэрэнд туссан байдлыг хариуцан эрхэлж эмхтгэсэн “Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь”¹-ныхоо материалд түшиглэн тоймлон үзүүлэхийг хичээв. Шашны суртал газар нутгийн нэрэнд туссан байдлыг бид нэг үзүүрт үзэл суртал ноёрхсон цагийн эрхшээлээр тэр бүр нарийвчлан судлалгүй өнөөг хүргэжээ. Асуудлыг хөндөн тавьсан цөөн бүтээлээс дурдвал: В.А.Казакевич², Н.Жамбалсүрэн³, А.Лувсандэндэв⁴, Ч.Догсүрэн⁵, Ш.Шагдар⁶, О.Сүхбаатар⁷, Э.Равдан⁸ зэрэг болно.

Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчуудын амьдрал ахуй нь байгаль дэлхийгээсээ шууд хамааралтай тул түүнд хандах хандлага нь суурин соёлтон үндэстнүүдээс гойд ялгаатай агаад маш өвөрмөц ажээ. Байгальтай харьцах, түүний биетийг нэрлэх зан үйл нь монголчуудын хувьд эдүгээ ХХI зуунд харьцангуй бүрэн уламжилж ирсэн нь судлаачдын сонирхлыг зүй ёсоор татахаар байна. Энэхүү асуудлыг бид бөөгийн болон бурхны шашны хэмээн зааглан

* Монгол Улсын Их Сургууль, Гадаад хэл, Соёлын Сургууль

¹ *Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь* (Манж, Богд хаант Монгол улсын үе), Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан, УБ., 2004, *Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь* (1970- 1980), Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан, УБ., 2004 (5 боть, 8 дэвтэр), *Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь* (БНМАУ-ын 1940-өөд оны үе), Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан, 2 дэвтэр, УБ., 2006

² В.А.Казакевич, *Современная монгольская топонимика* Л.изд. Академии наук СССР, 1934, 1-29 -р тал.

³ Н.Жамбалсүрэн, *Тибетские слова в монгольском языке* (диссертация на соискание учёной степени кандидата филологических наук), Москва, 1961, 96-99 –р тал.

⁴ А.Лувсандэндэв, *Монгол газар усны түвд нэрийн учир* “-Хэл бичгийн ухааны зарим асуудалд” (ШУА төв хэвлэл) УБ, 1980, 146-150 -р тал.

⁵ Ч.Догсүрэн, *Орчин цагийн монгол хэлэн дэх уулын тухайт нэр томъёо* “Хэл зохиол” XVI боть УБ, 1987, 92-97.

⁶ Ш.Шагдар, *Монгол газарзүйн нэрийн товч толь бичиг*, УБ., 2000.

⁷ О.Сүхбаатар, *Газар усны харь гаралтай нэр*-“Монголын газар усны нэрийн домог” УБ., 2001, 23-41 -р тал.

⁸ *Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь* (1970- 1980), Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан, УБ., 2004 (5 боть, 8 дэвтэр, CD хамт)

үзэж болох юм. Гэхдээ энэхүү зааг нь олон талаар болзвол агаад өнөөгийн шашны зан үйлд эл хоёр шашны зан үйлийг нарийн ялгах аргагүй уялдаа холбоотой болжээ.

Газар дэлхийн биетийг амьшуулах үзэл буюу анимизм⁹ нь маш эртний улбаатай бөгөөд хөлөөрөө бүх шашны эхлэл болсон бөөгийн үзэл баримтлалтай холбоотой. Хүн уулыг өөртэйгөө эсвэл түүний лус савдаг нь гэж үзсэн аливаа амьтантай дүйцүүлэн түүний бие эрхтний нэрээр нэрлэх нь зөвхөн монголчууд төдийгүй дэлхийн бусад үндэстнүүдэд нэлээн түгээмэл үзэгдэл бололтой. Гэвч суурин соёл иргэншилтэй оронд эдүгээ тэрхүү олон нэрээс улиран мартагдсан нь олон ажээ.¹⁰ Уулын нар гарах зүгт хандсан хэсгийг монголчууд: *өвөр (өлөг), зулай, сүх* буюу *магнай, хөмсөг, хөмөг, энгэр, эрүү, хөл, өвдөг, хуруу, бэл* г.м. нар жаргах талыг нь. *ар, дагз, гэзэг, сээр, сэрвэн, сэрвээ, сэртэн, хондлой, сүүл, хормой* г.м. үлдсэн хоёр талыг: *санчиг, шанаа, чих, мөр, хавирга, бөөр, сүүж, гуя, ташаа (ташуу, ташлан)* гэх мэтээр ялган нэрлэдэг байна.

Дээр дурдсан нэр нь байгалийн биетийг байршлаар нь заасан дэвсгэр буюу суурь нэр болой. Тэдгээрээс бидний “*Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь*”¹¹-д дэвсгэр нэрийн үүргээр орсон хүн амьтны бие эрхтний нэрийг жагсааж давтагдсан байдлаар нь үзүүлбэл дараах тоон үзүүлэлт харагдаж байна. Үүнд:

Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь /Манж, Богд хаант улсын үе, 1843-1924/	Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь /1940-өөд он/	Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь /1970-1980/
Ам-45	Ам-560	Ам -29966
Булуу-1	Бөгс-2	Багалзуур-1
Гуя-1	Булуу-11	Боом-62
Дух-1	Гуя-3	Бөгс-19
Зоо-1	Дух-4	Гуя-1
Нуруу-158	Зоо-48	Дух-18
/Өвдөг- 1	Магнай-4	Зоо-550
Суга -1	Нуруу-1069	Магнай -1
Сүв-1	Нүүр-3	Молцог- 35
Сүүл-1	Олгой-1	Нуруу-3126
Сэрвэн-2	Өвдөг-5	Нүүр-20
Сээр-1	Сүв-26	Олгой -1
Толгой-388	Сүүж-13	Өвдөг -6
Тохой-6	Сүүл-4	Суга-19

⁹ *Britanica Macropedia*, Volume 26, USA, 1995

¹⁰ Газар нутгийн оноосон нэр нь юуны өмнө хүний бие эрхтэн, сав суулга, нэхмэлийн машин, барилга байгууламж, түүний бүрэлдэхүүн хэсэг, цаг агаарын үзэгдлийн нэртэй байдаг тухай Н.И.Толстой (Толстой, 1969), Н.Кадмон (Kadmon, 2000) нар өгүүлсэн нь бий. Түүнчлэн Э.М.Мурзаев хүн амьтны бие эрхтний нэрээр азербайжан, орос, казах, араб, армян, монгол, уйгуур, балкар, түрэгмен, чукот, хятад, түрэг, вьетнам, тажик, солонгос, перс, зэрэг хэлэнд газрын биетийг нэрлэдэг тухай тодорхой баримтаар нотлон өгүүлжээ. (Мурзаев, 1974, 120-134). Миний бие энэ тухай тоймыг өөр нэгэн бүтээлдээ (Равдан, 2004, 120-134 талаас) дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

¹¹ *Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь* (БНМАУ-ын 1940-өөд оны үе), Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан, 2 дэвтэр, УБ., 2006

Хавирга -1	Сэрвэн-26	Сүв-47
Хамар-3	Сээр-17	Сүүж-702
Хоолой-32	Тархи-6	Сүүл-822
Хошуу-57	Толгой-1227	Сэрвэн-670
Хуруу-1	Тохой- 34	Сээр-10
Шанаа-2	Хамар-36	Тархи-1
Шил-16	Хоолой-53	Толгой-35657
	Хуруу-11	Тохой -383
	Хондлой-462	Хавирга-4
	Хошуу-53	Хамар-903
	Хэвэл-1	Хацар-1
	Шанаа-13	Хондлой-110
	Шил-20	Хоолой -4129
		Хөл-200 орчим
		Хуруу-154
		Хүзүү-2
		Шанаа-43
		Шил-70
Тольд орсон нийт нэрийн 720 буюу 6%-ийг эзэлж байна.	Тольд орсон нийт нэрийн 3712 буюу 9, 7 %-ийг эзэлж байна.	Тольд орсон нийт нэрийн 77134 нэр буюу 35,9 %-ийг эзэлж байна.

Эл хүснэгтээс бид хүн, амьтны бие эрхтнээр нэрлэсэн дэвсгэр нэр монгол газар нутгийн нэрэнд эзлэх жингээрээ багагүй болохыг нь үзэв. Түүнээс гадна дээрх төрлийн нэр нь газар нутгийн нэрэнд оноосон гишүүний үүргээр орсон нь тоо ба утгын хувьд үлэмж их байна. Монголчууд энэхүү оноосон нэрээр тодотгож байгаа газрын уг биетийн байршил, хэлбэр дүрс, өнгө зэргийг өөрийн болон амьтны бие эрхтэнтэй дүйлгэн нэрлэдэг нь мөн маш эртний улбаатай ажээ. Энд бид “Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь”¹²-д орсон дараах нэрийг зөвхөн давтамжаар нь дурдъя. Үүнд:

аарцаг (5), араа (4), арьс (4), алга (5), ам (74), аюулхай (3), бие (13), борви (7), бөгс (19), бугуй (1), булчирхай (1), булуу (198), бөөр (748), бэлхэнэг (2), гүзээ (16), гүрээ (3), гавал (6), гар (3), гуя (257), давсаг (9), дагз (1), дал (44), далавч (6), долоовор (2), дух (189), дэлүү (22), дэлэн (53), жавж (12), жигүүр (3), зүрх (484), зоо (9), зулай (5), магнай (199), молцог (35), мөч (3), мөр (4), мундаа (4), мээм (45), нүүр (224), нүд (301), нармай (1), найлзуур (1), нуруу (47), олгой (10), өвдөг (2), сүүж (187), сүвээ (41), сархинаг (4), санчиг (10), самсаа (2), соёо (101), суга (72), сэвлэг(1), сэвх (1), сэмж (5), сээр (109), сэрвэн (475), түнх (16), тагалицаг (1), тагнай (6), тавхай (32), ташаа (12), тахим (1), толгой (168), тохой (23), ухархай (8), ууц (2), уушиг (174), хүзүү (89), хүйс (303), хавирга (115), хамар (490), хацар (30), ходоод (33), хондлой (110), хонго (5), хоолой (45), хоншоор (44), хошноого (2), хошуу (404), хуруу (83), хөл (23), хуйх (5), хумс (7), хөмсөг (19), цанх (5), цөс (1), цээж (11), шүд (13), шагай (12), шилбэ (3), шийр (232), шил (45), шөрмөс (9), эвэр (19), эрүү (14), эрхий (4), элэг (21) зэрэг болно.

¹² Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (1970- 1980), Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан, УБ., 2004 (5 боть, 8 дэвтэр)

Энэ бүгд нь хүн төрөлхтөн ертөнцийн юм үзэгдлийг тайлбарлахдаа далдын хүч, сүсэг бишрэлийн үүднээс хандаж байсан эртний сэтгэлгээний үр дагавар болой. Тэрхүү сэтгэлгээний нэг хэсэг нь амьтныг дээдлэн шүтээн болгох /тотемизм/ (Britanica, 1995, p.540-541), түүнчлэн амьгүй байгалийн биетийг /анимизм/ амьшуулж, хүншүүлэн /фетишизм/ (Яблоков, 1998, с. 506) ойлгон нэрлэдэг эртний ёсон нь бурхны шашны зан үйлээр баяжин эдүгээ бидний үед уламжлагдан иржээ. Монголчууд гол төлөв зуны цагт хур бороо, өвөлдөө өнтэй сайхан өвөлжүүлэхийг уул овооныхоо лус савдагаас хүсэмжлэн Рэнчинпиранва (Эрдэнийн сан), Намдаг (Ариун сан), Бумсан (Бумын сан) зэрэг ариусах номоо айлтган лус савдагийн таалалд багтах зан үйлээ одоо хэрнээ үргэлжлэн үйлдсээр байна.

Бурхны шашныг дагаж манай орны цөөнгүй газар нутаг түвд нэртэй болжээ. Түүний зарим хэсгийг 1961 онд Н. Жамбалсүрэн гуай дэд эрдэмтний зэрэг горилж бичсэн нэг сэдэвт “Тибетские слова в монгольском языке” (Монгол хэлэнд орсон түвд үг) зохиолдоо оруулж тэмдэглэжээ. Үүнд: Улаанбаатар хотын урд этгээдэд оршдог Богдо Дунжингарво уул (mdun-skyon dkar-po) ‘цагаан, өмнө зүгийг тэтгэгч’, мөн Улаанбаатар хотын хойд этгээдэд оршдог нэгээхэн амыг Самбо-лхүндүвийн ам (bsam-pa Lhun-grubs) ‘бүхий хүслийг шийтгэн хангагч), Төв аймгийн Баянзүрх сумын Гандан ам (Gan-dun) ‘дунд чөмөг’ (Зохиогч хэлэхдээ: “хүний дунд чөмөгний ясыг санагдуулам хоёр толгой байдгийг тийнхүү нэрлэжээ” гэжээ. Хөвсгөл аймгийн нэгэн уулын нэр Ринчен-лхүнбо (rin-chen Lhun-po) ‘Эрдэний сүр бараа’ (Зохиогчийн тэмдэглэсэнээр: Тухайн үеийн “Үнэн” сонины сурвалжлагч Д.Бямбаа нутгийн өтгөсөөс асууж тогтоосноор эл уулыг түвд нэрээс нь өмнө “Хонин Өндөр” хэмээн нэрлэдэг байжээ. Чойбалсан аймгийн Дашбалбар уул (bkra-sis dpal-bar) ‘аз жаргал цогцлох’, Баяндун уул (ban dun), Завхан аймгийн Сэвжидгачен (gsi-brjed dga-chen) ‘тансаг, их баяр’, Хэнтий аймгийн Батноров (nor-bu) ‘Эрдэмт чулуу’ зэргийг дурдаж болно. Зохиогч түүнчлэн хуучин байсан хийдийн нэрээр нэрлэсэн зарим сум, нэгжийн нэрээс дурдсан байна. Үүнд: Булганы Дашинчилэн сум (bkra-sis che-glin) ‘үлэмж жаргалын хийд’, төмөр замын өртөө Шинэ Чойр (᠑oi ra) ‘Номт уул’, Хэнтий аймгийн Норовлин сум (nor-bu-glin) ‘Эрдэнийн чулуу’ хийдийн нэрээр, Жанчивлингийн рашаан-сувилал (byan chub-glin) ‘Тэгээний’ хийдийн нэрээр нэрлэсэн байна.¹³

Хожим нь А. Лувсандэндэв “Монгол газар усны түвд нэрийн учир” өгүүлэлдээ зарим нэрийг шинээр заажээ. Тэр нь: Улаанбаатарын хойд хэсэгт байдаг Дамбадаржаалин хийд (bstan-pa-dar-rgyas) ‘шашныг дэлгэрүүлэгч хийд’, Хөвсгөл аймгийн Ринченжугнай нуур (rin chen byung gnas) ‘эрдэнэ гарах орон’, Дундговийн аймгийн Цагаандэлгэр сумын Нороврээ уул (nor bu ri) ‘чандмань уул’, Улаанбаатар хотын баруун этгээдэд байдаг Зайсан хайрханы баруун Зэндмэнэ уулыг (tzinta mani) ‘зүрхэн эрдэнэ’, Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Дашлүн гол байгаад хожим Лүн болсон (hra ches lung) ‘өлзийт гол’ (Зохиогч үүнд хамааруулан Сүхбаатар аймгийн Наран сум дахь Лүн Хайрхан уул, Төв аймгийн Лүн сумын нутаг дахь Лүн толгой зэрэг бий гэж заажээ.¹⁴

¹³ Н.Жамбалсүрэн, *Тибетские слова в монгольском языке* (диссертация на соискание учёной степени кандидата филологических наук), Москва, 1961, ᠑6-99 –р тал.

¹⁴ А.Лувсандэндэв, *Монгол газар усны түвд нэрийн учир* “, Хэл бичгийн ухааны зарим асуудалд” (ШУА төв хэвлэл) УБ, 1980, 146-150 -р тал.

О. Сүхбаатар газар нутгийн түвд гаралтай цөөнгүй нэрийг заажээ. Тэдгээрээс өмнө заасан нэртэй давхардуулахгүйгээр түүвэрлэн өгүүлье. Үүнд: Түйн гол 'угаал', Дашдэрчин уул 'өлзийт их хүү сант уул', Дашинчилэн 'өлзий эргэсэн уул', Сэвжидбалбар уул 'сүр жавхлангийн цог заль бүрдсэн уул', Булнай уул 'өргөлийн орны уул', Дэрчинбумба 'их сангийн Бумба уул', Лувсанжалбын рашаан 'лусын эрхт хааны рашаан', Ханд хад 'огторгуйгаар явагч', Бадмаанямбуу уул 'лянхувийн зүрхэн уул', Намнан уул 'машид гийгүүлэгч язгуурын таван бурхны нэг', Наваанжалба уул 'хэлний эрхт ялгуулсан', Цамбагарав уул 'цагаан эсруа' зэрэг болно. Зохиогч: "Оюу толгой, Оюут нуур, Номингийн говь, Гиван толгой зэрэг нэрээс гадна Сэнгэ толгой 'арслан толгой', Сэврээ уул 'ирвэст уул' " зэрэг түвдээр нэршсэн багагүй газар бий гэжээ.¹⁵

Мөн зохиолд О.Сүхбаатар дараах самгарди гаралтай газар нутгийн нэрийг заажээ. Үүнд: Мандал овоо, Мандал толгой 'мантала', Очир толгой 'важра', Дамар чулуут 'дамару', Балин толгой 'Бали', Сансар уул 'самсаар', Биндэр уул 'вайдурьяа', Бигэр 'вакра', Рашаант 'rasayana', Мааньт 'маани', Буянт 'пуньяа', Судар уул 'сутра', Агруут 'сам агру', Сүмбэр уул 'сүмэрү', Хундар 'хумдхара буюу хумыг баригч', Ум аа хум толгой, Соёмбо толгой зэрэг болно.¹⁶

Дээр дурдсан судлаачдаас гаргасан цөөнгүй баримт нь түвд, самгарди гаралтай газар нутгийн нэрийн хувьд зөвхөн жишээ төдий юм. Өмнөх нэр дээр хүний нэр, түүнтэй утгын хувьд тэнцэж болохуйц бурхад, од эрхэс зэрэгт оноосон олон нэрийг наад зах нь оруулбал дээрх жишээ хэдэн мянгаар нэмэгдэнэ. Түүний өөр нэгэн нотолгоо болгож бид "*Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь*"¹⁷- д 'лам' нэр орсон газар нутгийн нэрийн цэсээр доор туршин үзье. Үүнд:

Лам:

Хэвтээ Ламын аараг (Өмнөговийн Гурвантэс), Бор Ламын ам (Говь-Алтайн Тайшир), Бүх Ламын ам (Ховдын Цэцэг), Даа Ламын ам (Өвөрхангайн Бүрд, Хархорин, Хэнтийн Өмнөдэлгэр, Хөвсгөлийн Бүрэнтогтох, Увсын Хяргас), Даа Ламын Овоот ам (Завханы, Яруу), Даа лам ам (Хөвсгөлийн Их-Уул), Лам ам (Хөвсгөлийн Шинэ-Идэр, Говь-Алтайн Бугат, Дорнодын Гурванзагал), Лам Нарын ам (Увсын Бөхмөрөн, Завханы Алдархаан), Лам Нарын Нүүр ам (Завханы Булнай), Лам Халзан ам (ХөвсгөлийнТүнэл), Лам Чулууны Өвөр ам (Дорнодын Чойбалсан), Ламт ам (Архангайн Цэцэрлэг), Ламтын ам (Хэнтийн Баян-Адарга, Батширээт), Ламхайн ам (Архангайн Чулуут), Ламын Овоотын ам (Төв аймгийн Сэргэлэн), Ламын Өтөгийн ам (Хөвсгөлийн Их-Уул), Ламын Шанд ам (Өвөрхангайн, Бүрд), Ламын Эрээн ам (Завханы Булнай), Муу Ламын ам (Говь-Алтайн, Тайшир), Богд Лам уул (Говь-Алтайн Баян-Уул), Бүх Ламын уул (Ховдын Цэцэг), Лам Малгайт уул (Дорнодын Баян-Уул), Лам Нарын уул (Увсын Бөхмөрөн), Лам Овоот уул (Булганы Хишиг-Өндөр), Лам Тайга уул (Хөвсгөлийн Улаан-Уул), Лам Хан уул (Төв аймгийн Эрдэнэсант), Лам Чулуу уул (Дорнодын Чойбалсан, Хэнтийн Баянхутаг), Лам уул

¹⁵ О.Сүхбаатар, *Газар усны харь гаралтай нэр*—"Монголын газар усны нэрийн домог" УБ., 2001, 39-р тал.

¹⁶ О.Сүхбаатар, *Газар усны харь гаралтай нэр*—"Монголын газар усны нэрийн домог" УБ., 2001, 40-41-р тал.

¹⁷ *Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь* (1970- 1980), Харуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан, УБ., 2004 (5 боть, 8 дэвтэр)

(Өвөрхангайн Хархорин, Төв аймгийн Баянхангай, Алтанбулаг, Булганы Баян-Агт, Дорнодын Гурванзагал), Ламлаг Зүрх уул (Хөвсгөлийн Цагаан-Үүр), Ламт уул (Булганы Гурванбулаг, Сүхбаатарын Дарьганга, Ховдын Эрдэнэбүрэн, Хэнтийн Баян-Адарга), Ламхай уул (Завханы Завханмандал), Ламхайн Овоо уул (Архангайн Чулуут), Ламын Гозгор уул (Төв аймгийн Борнуур, Хөвсгөлийн Рашаант, Их-Уул), Ламын Нүүрийн Гозгор уул (Завханы Идэр), Ламын Овоон уул (Хөвсгөлийн Галт), Ламын Овоот уул (Өвөрхангайн Хархорин), Ламын Өвөлжөө уул (Баянхонгорын Заг), Ламын Өндөр уул (Ховдын Дарви), Ламын Тайга уул (Хөвсгөлийн Баянзүрх), Ламын Ухаа уул (Дорнодын Сүмбэр), Ламын Хавтгай уул (Архангайн Ихтамир, Хөвсгөлийн Галт), Ламын Хайрхан уул (Дорнодын Сүмбэр, Халхгол), Ламын Халзан уул (Хөвсгөлийн Цагаан-Уул), Ламын Худагийн Улаан уул (Говь-Алтайн Алтай), Ламын Цахир уул (Хөвсгөлийн Алаг-Эрдэнэ), Муу Ламын Шовгор уул (Ховдын Цэцэг), Таван Ламын Тавьсан уул (Архангайн Булган), Таван Ламын Хар уул (Ховдын Мянгад), Урд Таван Ламын Цахир уул (Завханы Завханмандал), Хойд Таван Ламын Цахир уул (Завханы Завханмандал), Хөгшин Ламт уул (Ховдын Эрдэнэбүрэн), Хөх Лам уул (Завханы Баянхайрхан), Шар Лам уул (Завханы Сантмаргац), Лам Нарын ухаа (Архангайн Хашаат), Лам ухаа (Дорнодын Халхгол), Ламын Шандны ухаа (Сүхбаатарын Халзан), Ламын ухаа (Дорнодын Сүмбэр, Сүхбаатарын Эрдэнэцагаан, Хэнтийн Өмнөдэлгэр), Цагаан Ламын ухаа (Дундговийн Дэрэн), Лам Чулууны Ар хоолой (Дорнодын Чойбалсан), Лам хоолой (Дорнодын Баян-Уул), Ламтын хоолой (Сүхбаатарын Дарьганга, Төв аймгийн Баянцагаан), Ламын Овоот хоолой (Төв аймгийн Сэргэлэн), Ламын Өндөр хоолой (Өвөрхангайн Баян-Өндөр), Ламын хоолой (Хэнтийн Хэрлэн), Ламын хөдөө (Ховдын Булган), Ламын Шандны хөндий (Сүхбаатарын Халзан), Ламтын хөтөл (Хэнтийн Баян-Адарга), Ар Ламтын худаг (Сүхбаатарын Мөнххаан), Даа Лам худаг (Говь-Алтайн Алтай, Хөвсгөлийн Их-Уул), Лам Нарын Тооройн худаг (Баянхонгорын Баян-Өндөр), Лам Нарын Шанд худаг (Хэнтийн Галшир), Лам Нарын худаг (Увсын Зүүнговь), Лам Овоот худаг (Төв аймгийн Сэргэлэн), Лам Чулуу худаг (Дорнодын Матад), Ламтын худаг (Дорноговийн Айраг, Сүхбаатарын Асгат, Дарьганга), Ламын Ус худаг (Хэнтийн Галшир, Өмнөговийн Номгон), Ламын Хөвийн худаг (Сүхбаатарын Эрдэнэцагаан), Ламын Шанд худаг (Төв аймгийн Баяндэлгэр, Өмнөговийн Манлай), Ламын Шандын худаг (Төв аймгийн Баян, Сүхбаатарын Халзан), Ламын худаг (Ховдын Дарви, Дөргөн, Увсын Хяргас, Говь-Алтайн Цогт, Дэлгэр, Баянхонгорын Өлзийт, Дорнодын Цагаан-Овоо, Өвөрхангайн Зүйл, Бүрд, Төв аймгийн Баяндэлгэр, Баянхонгорын Баян-Овоо, Сүхбаатарын Уулбаян, Хэнтийн Галшир), Өвөр Ламтын худаг (Сүхбаатарын Мөнххаан), Таван Лам худаг (Завханы Завханмандал), Улаан Ламын худаг (Өвөрхангайн Тарагт), Хиа Ламын худаг (Говь-Алтайн Дэлгэр), Цагаан Лам худаг (Дундговийн Дэрэн), Лам Улааны хунхуй (Төв аймгийн Эрдэнэсант), Ламын Улаан хяр (Говь-Алтайн Дэлгэр), Ламын цохио (Төв аймгийн Эрдэнэсант), Лам чулуу (Дорнодын Сүмбэр), Ламын шанд (Говь-Алтайн Алтай), Лам Нарын элс (Увсын Зүүнговь), Ламын Шандны эрэг (Төв аймгийн Баян), Ламын Хийдийн балгас (Сэлэнгийн Цагааннуур), Даа Ламын булаг (Өвөрхангайн Бүрд), Лам булаг (Хөвсгөлийн Түнэл), Ламын булаг (Завханы Отгон, Говь-Алтайн Дэлгэр), Ламын Хөвийн булаг (Сүхбаатарын Эрдэнэцагаан), Улаан Ламын булаг (Өвөрхангайн Тарагт), Баруун Лам гол (Хөвсгөлийн Баянзүрх), Зүүн Лам гол

(Хөвсгөлийн Баянзүрх), Баян Ламын горхи (Төв аймгийн Эрдэнэ), Ламлаг (?) Давааны горхи (Хөвсгөлийн Цагаан-Үүр) Ламлаг (?) Зүрх горхи (Хөвсгөлийн Цагаан-Үүр), Ламын горхи (Завханы Отгон), Хүрээ Ламын горхи (Архангайн Цэцэрлэг), Лам Булагийн даваа (Хөвсгөлийн Түнэл), Ламлаг даваа (Хөвсгөлийн Цагаан-Үүр), Ламын даваа (Ховдын Булган), Ламын дөрөлж (Баянхонгорын Бууцагаан), Ламтын дөш (Сүхбаатарын Дарьганга), Ламын Байшингийн Цагаан дэрс (Төв аймгийн Баянжаргал), Лам жалга (Хөвсгөлийн Бүрэнтогтох, Баянхонгорын Заг, Архангайн Тариат, Жаргалант), Лам Нарын жалга (Говь-Алтайн Шарга), Ламын жалга (Хөвсгөлийн Түнэл), Лам Нарын мухар (Баянхонгорын, Хүрээмарал), Ламын Өвөлжөө нуруу (Төв аймгийн Мөнгөнморьт), Даа Ламын овоо (Завханы Яруу), Ламын овоо (Архангайн Өндөр-Улаан, Завханы Дөрвөлжин, Өмнөговийн Булган, Говь-Алтайн Цогт), Ламын Улаан овоо (Архангайн Цэцэрлэг), Бүх Ламын орой (Ховдын Цэцэг), Гэлэн Ламын сайр (Говь-Алтайн Алтай), Лам Нарын сайр (Говь-Алтайн Тайшир), Ламын Булагийн сайр (Говь-Алтайн Дэлгэр), Ламын Бууцын сайр (Ховдын Эрдэнэбүрэн), Ламын Сархиат сайр (Сэлэнгийн Цагааннуур), Ламын Тооройтын сайр (Баянхонгорын Баян-Өндөр), Ламын Усны сайр (Баянхонгорын Бөмбөгөр), Ламын Худагийн сайр (Говь-Алтайн Алтай, Увсын Хяргас), Ламын сайр (Говь-Алтайн Дэлгэр, Хөвсгөлийн Төмөрбулаг, Ховдын Дөргөн), Таван Ламын сайр (Ховдын Мянгад), Улаан Ламын сайр (Өвөрхангайн Тарагт), Хиа Ламын сайр (Говь-Алтайн Дэлгэр), Шар Ламын сайр (Говь-Алтайн Төнхил), Дархан Ламын салаа (Говь-Алтайн Алтай), Ламт таг (Булганы Хишиг-Өндөр), Ламын таг (Ховдын Мянгад), Ламтын тал (Сүхбаатарын Асгат), Ламын тойром (Дорноговийн Хатанбулаг), Ар Ламтын толгод (Сүхбаатарын Мөнххаан), Даа Ламын толгод (Говь-Алтайн Алтай), Дархан Ламын толгод (Говь-Алтайн Алтай), Лам Нарын толгод (Ховдын Дарви), Ламирамын толгод (Дундговийн Говь-Угтаал), Ламын толгод (Говь-Алтайн Цээл), Ламын Ширээ толгод (Өмнөговийн Номгон), Өвөр Ламтын толгод (Сүхбаатарын Мөнххаан), Улаан Ламын толгод (Өвөрхангайн Тарагт), Даа Лам толгой (Өвөрхангайн Бүрд, Хэнтийн Дэлгэрхаан), Доод Ламт толгой (Хөвсгөлийн Рэнчинлхүмбэ), Дээд Ламт толгой (Хөвсгөлийн Рэнчинлхүмбэ), Лам Зах толгой (Сэлэнгийн Сант, Зүүнбүрэн), Лам Нарын толгой (Завханы Яруу, Говь-Алтайн Жаргалант), Лам толгой (Увсын Өндөрхангай, Дорнодын Цагаан-Овоо, Архангайн Цэцэрлэг, Дундговийн Хулд, Сэлэнгийн Зүүнбүрэн Сант, Хөвсгөлийн Рашаант, Завханы Эрдэнэхайрхан, Лам Чулуут толгой (Дорнодын Матад), Ламирамын Улаан толгой (Дундговийн Говь-Угтаал), Ламтын толгой (Дорноговийн Айраг, Төв аймгийн Баянцагаан), Ламхай Овоо толгой (Сэлэнгийн Цагааннуур), Ламын Богоч толгой (Хөвсгөлийн Цэцэрлэг), Ламын Бууцны Өндөр толгой (Баянхонгорын Хүрээмарал), Ламын Гозгор толгой (Хөвсгөлийн Цагаан-Уул), Ламын Зараа толгой (Хөвсгөлийн Түнэл), Ламын Овгор толгой (Хөвсгөлийн Цагаан-Уул), Ламын Овоо толгой (Өмнөговийн Баяндалай), Ламын Овоот толгой (Завханы Отгон, Говь-Алтайн Чандмань, Өмнөговийн Ханхонгор, Сүхбаатарын Уулбаян, Төв аймгийн Сэргэлэн), Ламын Улаан толгой (Ховдын Мянгад, Говь-Алтайн Дэлгэр), Ламын Халзан толгой (Хөвсгөлийн Бүрэнтогтох), Ламын Хар толгой (Ховдын Дөргөн), Ламын Худагийн Хүрэн толгой (Говь-Алтайн Цогт), Ламын Цахир толгой (Ховдын Дөргөн), Ламын Чулуут толгой (Хэнтийн Хэрлэн), Ламын Шар толгой (Төв аймгийн Эрдэнэсант), Ламын Яст толгой (Хөвсгөлийн Рашаант), Улаан Ламын толгой (Төв аймгийн Сэргэлэн), Хиа Лам толгой (Говь-Алтайн Дэлгэр), Цагаан Ламын толгой

(Өвөрхангайн Төгрөг), Шар Ламын Гозгор толгой (Төв аймгийн Баянцогт), Шинэ Лам толгой (Завханы Яруу), Ламын Гэгээний Хийдийн туурь (Баянхонгорын Эрдэнэцогт), Ламын Хайрханы туурь (Дорнодын Халхгол), Ламын Хийдийн туурь (Дундговийн Сайхан-Овоо, Сүхбаатарын Сүхбаатар), Ламын Хүрээний туурь (Өмнөговийн Баяндалай), Ламын Нүүр Усан сан (Завханы Идэр) зэрэг болно.

“Лам” нэр оролцсон жишээ “Толь”-д 258 байна. Дээрх цэс газар нутгийн нэрэнд олон зууны турш монголчуудын амьдрал ахуйд бурхны шашны нөлөө үлэмж байсныг тов тодорхой харуулж байна. Нөгөөтэйгүүр, түвд язгуураас үүдэлтэй нэр зуугаар тоолшгүй их болох нь илэрхий. “Лам” оролцсон нэрээс гадна шашны холбогдолтой бусад нэр, ухагдахуун ч газар нутгийн нэрэнд цөөнгүй тусчээ. Заримаас нь дурдвал: *шажин 30, хийд 89, дуган 219, бурхан 329, хурал 53* орсон байна.

Шарын шашин Монголд дэлгэрч уул, овоо зэргийг улам бүр тахиx болсон нь газар нутгийн уугуул монгол олон нэр мартагдахад хүргэжээ. Энэ талаар В.А.Казакевич бичихдээ: *“Монгол овог аймгийнхны нутаглаж байгаа Төв Азийн бүхий л нутаг дэвсгэр дээр мянги мянган тахилгатай уул бий. Тэдгээр нь мөнх цастай өндөр, их уулс, дунд хирийн, заримдаа ерийн хамар, толгод хүртэл байдаг. Учир шалтгаан нь тухайн газрын тогтолцоо, эсвэл аливаа домог яриа, бас утга учир нь одоо үед бүрэн мартагдсан хуучин цагийн аль нэгэн үйл явдлын ул мөр байдаг. Нутаг газрынхан тэрхүү уулсыг аз жаргал, гай зовлон дуудах далд увьдастай хэмээн “номхон”, “дагшин” гэж хуваадаг. Дагшин уулсыг тусгай ном гүрэм унших, тахил өргөх зэргээр номхотгодог ажээ. Онцгой тохиолдолд нэрийг нь хүртэл сольдог байв. Тийм ч учраас Монголд эртний нэрээ хадгалсан уулс маш цөөн үлджээ. Уулыг шүтэх үзэл нь түүний нэрэнд шилждэг. Учир нь үгийг шүтэх хийгээд газар усны нэрийг цээрлэх ёсон Монголд өргөн тархсан байна.¹⁸Тахилгатай уул, толгодын тоо олон гэдэгт энд эргэлзэх зүйлгүй. Түүний нотолгоо нь тахилгатай олон хайрхны нэрийг багтаасан Ш. Шагдарын “Монгол газарзүйн нэрийн товч толь бичиг”¹⁹ болно.*

Харин эртний нэр цөөн үлджээ гэсэн В.А.Казакевичийн дүгнэлт харамсалтай нь үнэнд ойрхон бололтой. Түүнийг бид “Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь”-д жагсаасан *богд, хаан, хайрхан, тахилга* зэрэг газар нутгийн нэрийг цээрлэхэд орж болохуйц хэсэг үгээр туршаад үзье. Түүний учир нь монголчууд газар усаа тахиxдаа нэрийг цээрлэхийн сацуугаар “Богд”, “Хаан”, “Хан”, “Түшээ гүн” (Манжийн хаанаас Орхон голд хайрласан цол) зэргээр цол хэргэм хүртээн өргөмжилж байсан нь харьцангуй саяхан. Нөгөөтэйгүүр, дагшин лус савдагтай орон газраа “хайрхан”, “өлзийт”, “өгөөмөр” зэрэг үгээр эерүүлэн хэлдэг ёсон өнөө хирнээ хадгалагдаж үлджээ. Газар нутгийн нэрийг цээрлэх нь эдүгээ малчин ардын дунд амь бөхтэй хадгалагдаж байгаа нь нэн тэмдэглүүштэй агаад дэмжүүштэй. Тухайлбал, өөрийн төрсөн нутгаас зайдуу, жишээлбэл малын эрэл, ердийн хөсгөөр жин тээх, үгүйдээ гэхэд хот орон газарт хуучин цагт хоршоо, одоо бол пүүс, компаний мал тууж яваа монгол малчин хүн газрын нэрийг тэр бүр хэлдэггүй, уулыг “Хайрхан”, гол усыг “Рашаан” гэхийн хамт газар нутгийн нэрийг асууж лавлахыг тэвчих нь бий. Хэрэв заавал хэлэх шаардлагатай бол дээрх үгээр уг газар нутгийн нэрийг эерүүлэн хэлдэг түгээмэл ёстой. Газар нутгийн

¹⁸ В.А.Казакевич, *Современная монгольская топонимика* Л.изд. Академии наук СССР, 1934, 1-29

¹⁹ Ш.Шагдар, *Монгол газарзүйн нэрийн товч толь бичиг*, УБ., 2000

нэрийг асууж сонирхохыг тэд нэг их урьдал болгодоггүй. Учир нь тэдний хувьд монголоо алдсаны шинж, хүмүүжил муу, боловсрол багын илрэл болой. Эл ёсон хүний оноосон нэрэнд ч хамаатай. Ахмад настан, аав, ээж болон эхнэр, нөхөр бие биеийн нэрийг цээрлэн нэрийг нь *ах, эгч, манай хүн, гэрийн хүн, хүүхдүүдийн эх, эцэг, гээгтэй, хэцүү нэрт* зэргээр аль болохоор эерүүлэх, тойруулах зэрэг нь одоо хирнээ монгол боловсролтой гэр бүлийн хүрээнд үлджээ.

Одоо монгол газар нутгийн нэрийн санд дээр заасан хэдэн нэрийн эзлэх байр суурийг тогтоох гээд оролдъя. Үүнд:

Богд:

Аж Богд нуруу, Аж Богд уул, Ар Богд уул, Арц Богд ам, Ац Богд уул, Атас Богд уул, Бага Богд толгой (Дорноговийн Улаанбадрах), Бага Богд толгой (Баянхонгорын Баацагаан, Хөвсгөлийн Алаг-Эрдэнэ, Говь-Алтайн Баян-Уул), Бага Богд уул (Хөвсгөлийн Цагаан-Уул, Говь-Алтайн Тонхил, Завханы Алдархаан, Ховдын Цэцэг, Дарви, Завханы, Отгон, Дорноговийн Улаанбадрах), Баруун Богд уул, Баян Богд бригад, Баян Богд уул, Буурал Богд уул, Гурван Богд уул, Гэмвий Богд уул, Дулаан Богд уул, Дунд Чандмань Богд уул, Дунд Богд уул (Баянхонгорын Бууцагаан), Дунд Богд уул (Говь-Алтайн Шарга), Жаран Богд уул, Зүүн Богд уул (Өвөрхангайн Буруунбаян Улаан), Зүүн Богд уул (Өмнөговийн Манлай, Баянхонгорын Богд), Их Баян Богд уул, Их Богд толгой, Их Богд уул (Хөвсгөлийн Цагаан-Уул), Их Богд уул (Баянхонгорын Баян-Говь, Баянхонгорын, Богд), Ноён Богд уул (Өмнөговийн Гурвантэс, Баянхонгорын Баацагаан, Өмнөговийн Ноён), Өлзийт Богд уул, Өндөр Богд уул (Өмнөговийн Номгон), Өндөр Богд уул (Өмнөговийн Баян-Овоо), Сутай / Цаст Богд уул/ уул, Таван Богд уул, Талын Богд уул, Тэргүүн Богд уул (Баянхонгорын Баянговь), Хүрэн Богд уул, Хан Богд уул (Өмнөговийн Манлай), Хасагт Богд уул, Хасагтын Гурван Богд уул, Хойд Богд толгой, Хойд Богд уул, Хойд Цаст Богд уул (Ховдын Мөст), Хойд Цаст Богд уул (Ховдын Зэрэг), Хярын Богд уул, Хэцүү Богд уул, Цагаан Богд уул, Цаст Богд уул (Говь-Алтайн Дарви, Ховдын Дарви), Чойрын Богд уул (Дорноговийн Сүмбэр, Даланжаргалан), Шилийн Богд уул (Сүхбаатарын Дарьганга) зэрэг болно. Богдын уул, ам, худаг, толгой, хөндий 20 (Ар Богдын гол, Арц Богдын нуруу, Бага Богдын ам, Бага Богдын гол, Бага Богдын худаг, Жаран Богдын сайр, Зүүн Богдын нуруу, Зүүн Богдын уул, Зөөлөн Богдын даваа (Говь-Алтайн Алтай), Зөөлөн Богдын даваа (Говь-Алтайн Бугат), Зөөлөн Богдын нуруу, Их Богдын ам, Их Богдын гол, Их Богдын нуруу, Их Богдын нуруу, Ноён Богдын хөндий, Ноён Богдын Хөх толгод, Өвөр Богдын гол, Хүрэн Богдын нуруу, Хүрэн Богдын худаг Ховдын Алтай) зэрэг болно.

“Богд”-ыг ерийн олон түмэн зөвхөн “уул”-тай хэрэглэгддэг хавсрал нэр хэмээн ойлгодог. Тэр нь арга ч үгүй бололтой. Учир нь Богд уул бидний “*Зүйлчилсэн толь*”-д 79 байна. Гэхдээ “Богд” дан уул хараахан биш. Үлдсэн 54 гаруй нэр нь: *сайр, нуруу, гол, ам, даваа, толгой, худаг, хөндий* зэрэг дэвсгэр нэртэй нийлэмж бүтээсэн байна.

Хаан:

“Хаан” нэр орсон газар нутгийн 178 нэр “*Зүйлчилсэн толь*”-д тэмдэглэгдсэн байна. Үүнд: Баян Хааны ам (Дорнодын Баяндун), Дэлгэр Хааны ам (Хөвсгөлийн

Тосонцэнгэл, Хэнтийн Баян-Овоо), Номхон Хааны ам (Сэлэнгийн Жавхлант), Унаат Хаан ам (Сэлэнгийн Ерөө), Хаан Буурын ам (Баянхонгорын Жаргалант), Хаан Давааны Ар ам (Хөвсгөлийн Цагаан-Уул), Хаан Давааны Өвөр ам (Хөвсгөлийн Цагаан-Уул), Хаан Овооны ам (Баянхонгорын Өлзийт), Хааны ам (Хөвсгөлийн Цэцэрлэг), Хар Хааны ам (Говь-Алтайн Тайшир), Бага Баян Хаан уул (Хэнтийн Өмнөдэлгэр), Бага Дулаан Хаан уул (Хөвсгөлийн Рашаант, Сэлэнгийн Шаамар), Бага Хаан уул (Төв аймгийн Дэлгэрхаан, Сэлэнгийн Ерөө, Булганы Гурванбулаг), Баруун Баян Хаан уул (Хэнтийн Батноров), Бат Хаан уул (Өвөрхангайн Бүрд), Баян Хаан Овоот уул (Булганы Бүрэгхангай), Баян Хаан уул (Сэлэнгийн Шаамар, Сэлэнгийн Алтанбулаг, Дорнодын Баяндун, Хөлөнбуйр, Чулуунхороот, Сүхбаатарын Мөнххаан, Баян-Уул, Хэнтийн Өмнөдэлгэр, Хэнтийн Мөрөн, Говь-Алтайн Шарга), Баян Хаант уул (Булганы Орхон), Будлан Хаан уул (Хэнтийн Өмнөдэлгэр), Бүрэн Хаан уул (Хөвсгөлийн Түнэл, Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул, Дорнодын Баяндун, Баян-Уул, Булганы Могод), Бэрх Дэлгэр Хаан уул (Хэнтийн Батноров), Дархан Хаан уул (Сүхбаатарын Сүхбаатар, Хэнтийн Дархан), Дулаан Хаан уул (Архангайн Батцэнгэл, Өлзийт, Жаргалант, Төв аймгийн Эрдэнэ, Мөнгөнморьт, Хөвсгөлийн Тариалан, Булганы Хутаг-Өндөр), Дулаан Хааны Зүрх уул (Төв аймгийн Эрдэнэ), Дулаан Хааны Өндөр уул (Төв аймгийн Мөнгөнморьт), Дэлгэр Хаан уул (Хэнтийн Батноров, Төв аймгийн Дэлгэрхаан, Хөвсгөлийн Тосонцэнгэл, Улаан-Уул, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Сэлэнгийн Баруунбүрэн, Алтанбулаг, Жавхлант, Сүхбаатарын Түвшинширээ, Хэнтийн Дэлгэрхаан, Өмнөдэлгэр, Баян-Овоо), Дэлгэр Хааны Зүүн Дүнхэр уул (Хэнтийн Дэлгэрхаан), Естэй Хаан уул (Сэлэнгийн Мандал, Ерөө), Жаргалт Хаан уул (Хэнтийн Жаргалтхаан, Өмнөдэлгэр), Зүүн Баян Хаан уул (Хэнтийн Батноров), Их Баян Хаан уул (Дорнодын Баян-Уул), Их Дулаан Хаан уул (Хөвсгөлийн Рашаант), Лог Хаан уул (Төв аймгийн Эрдэнэсант), Мөнх Хаан уул (Сүхбаатарын Мөнххаан, Хэнтийн Батноров), Мөст Хаан Эрээн уул (Сэлэнгийн Ерөө), Нагал Хаан уул (Төв аймгийн Эрдэнэ), Номон Хаан уул (Сүхбаатарын Мөнххаан), Номхон Хаан уул (Сэлэнгийн Жавхлант), Өндөр Хаан уул (Хөвсгөлийн Тариалан, Хэнтийн Мөрөн, Булганы Орхон), Товхон Хаан уул (Сэлэнгийн Цагааннуур), Унаат Хаан уул (Сэлэнгийн Ерөө), Үүлэн Хаан уул (Дорнодын Чулуунхороот), Хаан Буур уул (Баянхонгорын Жаргалант), Хаан Давааны уул (Хөвсгөлийн Цагаан-Уул), Хаан Овоо уул (Хөвсгөлийн Мөст), Хаан Овоот уул (Баянхонгорын Өлзийт), Хаан Худагийн Шовх уул (Төв аймгийн Алтанбулаг), Хаан уул (Баян-Өлгийн Цэнгэл, Булганы Орхон), Хаан Булаг уул (Өвөрхангайн Богд), Хөгнө Хаан уул (Булганы Гурванбулаг), Хурам Хаан уул (Дорнодын Баяндун), Хэнтийн Хаан уул (Хэнтийн Өмнөдэлгэр), Шоргойтын Баян Хаан уул (Хэнтийн Цэнхэрмандал), Эрдэнэ Хаан уул (Хэнтийн Өмнөдэлгэр), Идэрмэг Баян Хаан ухаа (Хэнтийн Батноров), Хаан Овооны хамар (Баянхонгорын Өлзийт), Баян Хааны хоолой (Дорнодын Хөлөнбуйр), Баян Хааны хөндий (Сүхбаатарын Мөнххаан), Хааны Цагаан хөтөл (Төв аймгийн Дэлгэрхаан), Хааны хөтөл (Баян-Өлгийн Алтанцөгц), Моюнчир Хааны Гэрэлт хөшөө (Булганы Сайхан), Баян Хааны Уулын худаг (Дорнодын Чулуунхороот), Баян Хааны Хөндийн худаг (Дорнодын Хөлөнбуйр), Баян Хааны худаг (Хэнтийн Батноров, Дорнодын Чулуунхороот), Дэлгэр Хаан худаг (Хэнтийн Өмнөдэлгэр), Дэлгэр Хааны Өвдөг худаг (Хэнтийн Өмнөдэлгэр), Дэлгэр Хааны худаг (Хөвсгөлийн Тосонцэнгэл), Хаан Овоогийн худаг (Дундговийн Сайнцагаан), Хаан Тамга худаг (Өвөрхангайн

Хархорин), Хаан Ус худаг (Өмнөговийн Баяндалай), Хаан худаг (Төв аймгийн Алтанбулаг), Хааны Баруун худаг (Баян-Өлгийн Алтанцөгц), Хааны Зүүн худаг (Баян-Өлгийн Алтанцөгц), Хааны Амны худаг (Баян-Өлгийн Алтанцөгц), Хааны худаг (Хэнтийн Баянхутаг), Хаан Булагийн худаг (Увсын Малчин), Хайрт Хааны худаг (Төв аймгийн Баянцогт), Дэлгэр Хааны хэц (Сэлэнгийн Алтанбулаг), Бага Хааны энгэр (Булганы Гурванбулаг), Баян Хааны булаг (Хэнтийн Батноров), Дэлгэр Хааны булаг (Хэнтийн Өмнөдэлгэр), Хаан булаг (Өвөрхангайн Богд), Хааны Рашаан булаг (Төв аймгийн Дэлгэрхаан), Ар Дулаан Хааны гол (Төв аймгийн Эрдэнэ), Бага Хаан гол (Сэлэнгийн Ерөө), Дулаан Хааны гол (Төв аймгийн Мөнгөнморьт, Хөвсгөлийн Улаан-Уул), Хааны гол (Хөвсгөлийн Цэцэрлэг), Дэлгэр Хааны горхи (Хэнтийн Өмнөдэлгэр), Ар Дулаан Хааны даваа (Төв аймгийн Эрдэнэ), Хаан даваа (Хөвсгөлийн Цагаан-Уул), Хааны даваа (Хөвсгөлийн Цэцэрлэг), Номон Хааны довцог (Дорнодын Сүмбэр), Номин Хааны дэнж (Төв аймгийн Лүн), Бүрэн Хаан жалга (Хөвсгөлийн Галт), Хааны Худагийн зоо (Баян-Өлгийн Алтанцөгц), Дулаан Хааны нуруу (Хөвсгөлийн Тариалан), Дэлгэр Хааны нуруу (Хэнтийн Өмнөдэлгэр, Дэлгэрхаан), Хаан Буурын нуруу (Баянхонгорын Жаргалант), Хаан Овооны нуруу (Баянхонгорын Өлзийт), Баян Хааны Шүүт нуур (Хэнтийн Баян-Овоо), Бүрэн Хаан овоо (Хөвсгөлийн Бүрэнтогтох, Алаг-Эрдэнэ), Дэлгэр Хаан овоо (Хөвсгөлийн Арбулаг), Хаан олом (Булганы Гурванбулаг), Дэлгэр Хааны өвөр (Хөвсгөлийн Чандмань-Өндөр). Их Хааны өвөр (Төв аймгийн Дэлгэрхаан), Хаан Булагийн сайр (Увсын Малчин), Их Хэнтийн Хааны сарьдаг (Хэнтийн Өмнөдэлгэр), Хааны суга (Хөвсгөлийн Цэцэрлэг), Баян Хааны тойром (Дорнодын Чулуун-хороот), Бага Хааны Үзүүр толгой (Булганы Гурванбулаг), Бат Хаан толгой (Хэнтийн Баян-Овоо, Дорнодын Хөлөнбуйр, Сүхбаатарын Түмэнцогт), Баян Хааны Холбоо толгой (Дорнодын Хөлөнбуйр), Хаантын Овоот толгой (Архангайн Хашаат), Хааны Буурь толгой (Увсын Ховд), Хааны Хүрэн толгой (Төв аймгийн Дэлгэрхаан), Мөнх Хааны Хийдийн туурь (Сүхбаатарын Мөнххаан) зэрэг болно.

“Хаан” нь “Богд”-ыг бодвол монгол газар нутгийн нэрэнд тооны хувьд илүүтэй хэрэглэгддэг болох нь дээрх цэсээс харагдаж байна. Дээрх тоон үзүүлэлтэд “хан”-ыг нэмж үзэх хэрэгтэй. “Хан” хэлбэрээр бидний “Зүйлчилсэн толь”²⁰-д нийт 52 нэр, “Ханы” хэлбэрээр 26 нэр тэмдэглэгджээ. “Хаан”, “хан” нь, нөгөөтэйгүүр нэрийн бүрэлдэхүүнээс ажвал газар нутгийн нэрийн цээрээс үүдсэн өргөмж нэр байхаасаа илүү түүхэн дурсгалт хүмүүсийн үйлтэй холбоотой байх талтай байна. Харин “хаан”, “хан”-тай харьцуулбал “Хайрхан”, “тахилга” нэр газар нутгийн нэрийн цээрд илүү хамаатай бөлгөө.

Хайрхан:

Хар Хайрханы аараг (Говь-Алтайн Цогт), Цагаан Хайрханы адарга (Ховдын Буянт), Ар Хайрханы ам (Баянхонгорын Баацагаан), Бага Хайрхан ам (Баянхонгорын Гурванбулаг), Бага Хайрханы ам (Баян-Өлгийн Сагсай), Баян Хайрханы Баруун ам (Ховдын Буянт), Баян Хайрханы ам (Баянхонгорын Гурванбулаг, Сэлэнгийн Сант,

²⁰ Монголын газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (1970-1980), Хариуцан эрхэлж эмхтгэсэн Э. Равдан, УБ., 2004 (5 боть, 8 дэвтэр)

Өвөрхангайн Бүрд), Бэрхийн Хайрханы ам (Архангайн Хотонт), Гурван Хайрханы ам (Завханы Баянхайрхан), Их Хайрханы ам (Завханы Нөмрөг), Ногоон Хайрхан ам (Говь-Алтайн Тайшир), Ноён Хайрханы ам (Баянхонгорын Гурванбулаг), Өвөр Хайрханы ам (Баянхонгорын Баацагаан), Үнэгт Хайрханы ам (Баянхонгорын Гурванбулаг), Хайрхан Бүрдийн ам (Төв аймгийн Алтанбулаг), Хайрхан Давааны ам (Хөвсгөлийн Тариалан, Баянхонгорын Галуут), Хайрхан ам (Говь-Алтайн Дарви, Баянхонгорын Заг, Жаргалант Бууцагаан), Хайрхан Жаргалант ам (Баянхонгорын Галуут), Хайрханы Ар ам (Архангайн Хангай), Хайрханы Давааны ам (Баянхонгорын Эрдэнэцогт, Галуут), Хайрханы ам (Говь-Алтайн Төгрөг, Бигэр, Бугат, Эрдэнэ, Цээл, Баянхонгорын Жаргалант, Заг, Жаргалан, Завханы Нөмрөг, Архангайн Өгийнуур, Өлзийт, Хашаат, Алдархаан, Өвөрхангайн Нарийнтээл, Хайрхандулаан, Төв аймгийн Сэргэлэн, Баян-Өлгийн Дэлүүн), Хайрханы Урд ам (Завханы Баянхайрхан), Хайрханы Шанд ам (Баянхонгорын Шинэжинст), Хайрханы Шил ам (Баянхонгорын Галуут), Хан Хайрханы ам (Говь-Алтайн Эрдэнэ), Хойд Дэл Хайрханы ам (Баянхонгорын Галуут), Хонгор Хайрханы ам (Хэнтийн Биндэр), Хөх Хайрхан ам (Баянхонгорын Бууцагаан), Хундага Хайрхан ам (Баян-Өлгийн Булганы), Цагаан Хайрхан ам (Өмнөговийн Ханбогд), Цагаан Хайрханы ам (Баянхонгорын Баян-Өндөр, Өвөрхангайн Богд, Завханы Ургамал), Цогт Хайрхан ам (Баянхонгорын Жаргалант, Архангайн Ихтамир), Улаан Хайрханы ам (Говь-Алтайн Бугат), Авдаг Хайрхан уул (Булганы Гурванбулаг), Аврага Хайрхан уул (Говь-Алтайн Цогт), Азар Хайрхан уул (Сэлэнгийн Сант), Алаг Хайрхан уул (Баян-Өлгийн Булган, Говь-Алтайн Бугат, Баянхонгорын Бууцагаан, Увсын Хяргас, Говь-Алтайн Чандмань, Шарга, Эрдэнэ), Алтан Хайрхан уул (Дундговийн Луус, Говь-Алтайн Алтай, Завханы Эрдэнэхайрхан, Ар Улаан Хайрхан уул (Говь-Алтайн Төгрөг), Арслан Хайрхан уул (Баянхонгорын Баянцагаан, Говь-Алтайн Цогт, Эрдэнэ), Арцат Хайрхан уул (Говь-Алтайн Тонхил), Асгар Хайрхан уул (Сэлэнгийн Сант), Асгат Хайрхан уул (Архангайн Өлзийт, Төв аймгийн Эрдэнэ), Ачит Хайрхан уул (Сэлэнгийн Цагааннуур), Ашиг Хайрхан уул (Өмнөговийн Баян-Овоо), Баатар Хайрхан уул (Төв аймгийн Баянчандмань, Улаанбаатар, Партизан хороо, Ховдын Буянт), Баг Шийр Хайрхан уул (Өвөрхангайн Богд), Бага Буурал Хайрхан уул (Говь-Алтайн Төгрөг), Бага Бүрэн Хайрхан уул (Завханы Яруу), Бага Дөш Хайрхан уул (Говь-Алтайн Бугат, Жаргалант), Бага Мөнх Хайрхан уул (Баян-Өлгийн Сагсай), Бага Ноён Хайрхан уул (Баянхонгорын Гурванбулаг), Бага Тас Хайрхан уул (Завханы Ургамал), Бага Хайрхан уул (Архангайн Өлзийт, Дундговийн Өлзийт, Сайнцагаан, Увсын Зүүнхангай, Төв аймгийн Алтанбулаг, Баян-Өлгийн Бугат, Завханы Завханмандал, Идэр, Булнай, Ургамал, Алдархаан, Хөвсгөлийн Цагаан-Уул, Говь-Алтайн Баян-Уул, Бугат, Хөхморьт, Булганы Гурванбулаг, Баян-Өлгийн Сагсай, Өмнөговийн Сэврэй, Ховдын Дөргөн, Увсын Цагаанхайрхан, Хөвсгөлийн Бүрэнтогтох, Дорноговийн Хатанбулаг, Алтанширээ, Баянхонгорын Гурванбулаг), Балгант Хайрхан уул (Баянхонгорын Галуут), Бамбагар Хайрхан уул (Говь-Алтайн Шарга), Банзад Хайрхан уул (Өмнөговийн Гурвантэс), Бараан Хайрхан уул (Өмнөговийн Ханхонгор), Баруун Суврага Хайрхан уул (Дорноговийн Хатанбулаг), Баруун Хайрхан уул (Дундговийн Дэлгэрхангай), Баруун Хайрхан уул (Өвөрхангайн Өлзийт, Баян-Өлгийн Дэлүүн), Баян Зүрх Хайрхан уул (Завханы Алдархаан), Баян Хайрхан уул (Архангайн Тариат, Батцэнгэл, Өндөр-Улаан, Өлзийт, Чулуут, Дундговийн Эрдэнэдалай, Өлзийт,

Өвөрхангайн Тарагт, Хайрхандулаан, Бүрд, Төв аймгийн Жаргалант, Сэлэнгийн Сант, Булганы Баян-Агт, Завханы Баянтэс, Ховдын Манхан, Буянт, Чандмань, Зэрэг, Буянт, Увсын Малчин, Булганы Могод, Хөвсгөлийн Жаргалант, Баянхонгорын Галуут, Гурванбулаг, Завханы Тэлмэн), Бичигт Хайрхан уул (Архангайн Өндөр-Улаан), Бор Овоо Хайрхан уул (Баянхонгорын Бууцагаан, Хүрээмарал), Бор Хайрхан уул (Өвөрхангайн Хайрхандулаан, Завханы Алдархаан, Баян-Өлгийн Сагсай, Завханы Цагаанчулуут, Баянхонгорын Баян-Өндөр, Увсын Хяргас, Говь-Алтайн Чандмань, Дорноговийн Мандах, Баянхонгорын Галуут), Боргилт Хайрхан уул (Дундговийн Эрдэнэдалай, Төв аймгийн Бүрэн), Ботго Хайрхан уул (Дорноговийн Эрдэнэ), Бөөр Хар Хайрхан уул (Баянхонгорын Заг), Буга Хайрхан уул (Өвөрхангайн Нарийн-тээл, Завханы Дөрвөлжин, Говь-Алтайн Бугат, Дэлгэр, Бунхан Хайрхан уул (Архангайн Булганы), Бунханта Хайрхан уул (Өвөрхангайн Зүүнбаян-Улаан), Бургаст Хайрхан уул (Баян-Өлгийн Бугат, Толбо), Бургастын Хайрхан уул Баян-Өлгийн Толбо), Буурал Хайрхануул (Баян-Өлгийн Булган, Өмнөговийн Баян-Овоо, Баянхонгорын Бууцагаан, Баян-Өндөр, Ховдын Мөнххайрхан), Бухт Хайрхан уул (Өмнөговийн Баян-Овоо), Бүргэдтэй Хайрхан уул (Баян-Өлгийн Дэлүүн, Ховдын Дуут), Бүрэг Хайрхан уул (Баянхонгорын Бууцагаан) Бүрэн Хайрхан уул (Говь-Алтайн Жаргалант, Баянхонгорын Баянбулаг, Ховдын Булганы, Увсын Өндөрхангай, Говь-Алтайн Цээл), Бүс Хайрхан уул (Говь-Алтайн Тонхил, Баянхонгорын Баян-Өндөр, Бэрх Хайрхан уул (Төв аймгийн Лүн, Сэлэнгийн Хонгор хороо), Галт Хайрхан уул (Дундговийн Сайхан-Овоо, Гарьд Хайрхан уул (Говь-Алтайн Эрдэнэ), Гозгор Хайрхан уул (Архангайн Ихтамир, Баянхонгорын Галуут), Гос Хайрхан уул (Өвөрхангайн Богд), Гуа Хайрхан уул (Өвөрхангайн Тарагт), Гуна Хайрхан уул (Төв аймгийн Баянцогт), Гурван Хайрхан уул (Төв аймгийн Баян, Говь-Алтайн Баян-Уул, Бугат, Шарга, Завханы Баянтэс, Гэдгэр Хайрхан уул (Баянхонгорын Бууцагаан), Дааган Хайрхан уул (Увсын Зүүнхангай), Дааган Хайрханы Шовгор уул (Увсын Зүүнхангай), Далай Хайрхан уул (Баянхонгорын Жаргалант), Дарамт Хайрхан уул (Баянхонгорын Галуут), Доод Хайрхан уул (Өмнөговийн Хүрмэн), Доромт Хайрхан уул (Баянхонгорын Эрдэнэцогт), Дөрвөлжин Хайрхан уул (Говь-Алтайн Хөхморьт, Баянхонгорын Баян-Өндөр), Дөш Хайрхан уул (Дундговийн Хулд), Дулаан Хайрхан уул (Архангайн Хангай, Баян-Өлгийн Ногооннуур, Завханы Тэлмэн), Дунд Суварга Хайрхан уул (Дорноговийн Хатанбулаг), Дунд Хайрхан уул (Улаанбаатар Гачуурт хороо, Баянхонгорын Баян-Өндөр, Дуулгант Хайрхан уул (Баянхонгорын Гурванбулаг), Дуут Хайрхан уул (Өвөрхангайн Зүүнбаян-Улаан, Говь-Алтайн Хөхморьт, Өмнөговийн Номгон), Дэвхрэг Хайрхан уул (Өмнөговийн Ханбогд), Дэлгэр Хайрхан уул (Төв аймгийн Өндөрширээт, Завханы Завханмандал, Увсын Хяргас, Өндөрхангай), Дээд Хайрхан уул (Өмнөговийн Хүрмэн), Ёл Хайрхан уул (Говь-Алтайн Баян-Уул, Говь-Алтайн Дарви, Баянхонгорын Заг), Жанчив Хайрхан уул (Архангайн Булган), Жаргалант Хайрхан уул (Сэлэнгийн Цагааннуур, Баян-Өлгийн Сагсай), Залаа Хайрхан уул (Өмнөговийн Ханхонгор, Говь-Алтайн Цогт, Эрдэнэ) Зараа Хайрхан уул (Говь-Алтайн Эрдэнэ), Зогсоо Хайрхан уул (Увсын Завхан), Зоо Хайрхан уул (Дорноговийн Хатанбулаг), Зоргол Хайрхан уул (Төв аймгийн Баян-Өнжүүл), Зос Хайрхан уул (Сэлэнгийн Цагааннуур), Зүрх Хайрхан уул (Өмнөговийн Гурвантэс, Баянхонгорын Эрдэнэцогт), Зүүн Суврага Хайрхан уул (Дорноговийн Хатанбулаг), Зүүн Хайрхан уул (Дундговийн Дэлгэрхангай,

Өвөрхангайн Зүйл), Зүүн Хайрханы Хүрд уул (Архангайн Цэнхэр), Их Авзага Хайрхан уул (Өвөрхангайн Тарагт), Их Буурал Хайрхан уул (Говь-Алтайн Төгрөг), Их Бүрэн Хайрхан уул (Завханы Яруу), Их Дөш Хайрхан уул (Говь-Алтайн Бугат, Жаргалант), Их Дулаан Хайрхан уул (Баянхонгорын Заг), Их Мөнх Хайрхан уул (Баян-Өлгийн Сагсай), Их Хайрхан Тэмдэгт уул (Завханы Нөмрөг), Их Хайрхан уул (Дундговийн Өлзийт, Сайнцагаан, Төв аймгийн Өндөрширээт, Завханы Идэр, Хөвсгөлийн Цагаан-Уул, Завханы Нөмрөг, Алдархаан, Өмнөговийн Сэврэй, Ховдын Дөргөн, Хөвсгөлийн Бүрэнтогтох, Дорноговийн Хатанбулаг), Их Шийр Хайрхан уул (Өвөрхангайн Богд), Ихэр Хайрхан уул (Баянхонгорын Бууцагаан), Ламын Хайрхан уул (Дорнодын Сүмбэр, Халх гол), Лхаа Хайрхан уул (Говь-Алтайн Алтай), Мааньт Хайрхан уул (Өмнөговийн Баян-Овоо), Мандал Хайрхан уул (Баян-Өлгийн Сагсай, Улаанхус, Баянхонгорын Баян-Овоо, Бөмбөгөр), Могойт Хайрхан уул (Өвөрхангайн Тарагт), Монгол Хайрхан уул (Баян-Өлгийн Булган, Өмнөговийн Сэврэй), Морцлол Хайрхан уул (Архангайн Чулуут), Мөнгөлөг Хайрхан уул (Говь-Алтайн Эрдэнэ), Мөнх Хайрхан уул (Баян-Өлгийн Булган, Ховдын Мөнххайрхан), Намагийн Хайрхан уул (Архангайн Цэнхэр), Наран Хайрхан уул (Ховдын Дуут, Буянт), Ногоон Суврага Хайрхан уул (Сэлэнгийн Цагааннуур, Түшиг), Ноён Хайрхан уул (Өвөрхангайн Өлзийт, Говь-Алтайн Цогт, Баянхонгорын Гурванбулаг), Норов Хайрхан уул (Говь-Алтайн, Дэлгэр), Овоот Хайрхан уул (Архангайн Ихтамир), Онгон Хайрхан уул (Төв аймгийн Бүрэн, Хөвсгөлийн Бүрэнтогтох), Онц Хайрхан уул (Завханы Цагаанхайрхан), Онч Хайрхан уул (Өмнөговийн Номгон), От Хайрхан уул (Дорноговийн Хатанбулаг), Очир Хайрхан уул (Говь-Алтайн Төгрөг, Баянхонгорын Баянбулаг, Говь-Алтайн Эрдэнэ, Баянхонгорын Хүрээмарал), Очирт Хайрхан уул (Өмнөговийн Хүрмэн), Өлзийт Хайрхан уул (Архангайн Ихтамир, Завханы Идэр, Баянхонгорын Эрдэнэцогт, Өмнө Хайрхан уул (Баян-Өлгийн Бугат, Толбо), Өндөр Хайрхан уул (Архангайн Чулуут, Хөвсгөлийн Тариалан, Баян-Өлгийн Улаанхус, Өмнөговийн Баян-Овоо, Баянхонгорын Галуут, Бөмбөгөр, Эрдэнэ-Цогт, Говь-Алтайн Шарга, Саадаг Хайрхан уул (Завханы Алдархаан, Баянхонгорын Баян-Өндөр, Саарал Хайрхан уул (Баян-Өлгийн Булган), Сант Хайрхан уул (Өвөрхангайн Хужирт), Сар Хайрхан уул (Завханы Дөрвөлжин), Сариг Хайрхан уул (Дундговийн Луус), Сахалт Хайрхан уул (Архангайн Хайрхан, Булганы Сайхан, Баянхонгорын Галуут) зэрэг болно.

“Толь”-д “Хайрхан” нэр орсон 939 нэр бүхий газрын биет бүртгэгджээ. Энэ бол бага тоо биш. Өмнөх “хаан”, “хан”-тай дүйлгэвэл эл нэр нь газар нутгийн нэрийн цээрээс үүдсэн нь эргэлзээгүй. Эл нэр нь уг газар нутгийн нэрийг “Хайрхан уул” загвараар бүрэн орлохоос гадна “Сариг Хайрхан уул” загвараар жинхэнэ нэрийг эерүүлэх тохиолдол цөөнгүй бий. Үүнийг ялгавартай үзэх хэрэгтэй. Эерүүлбэл эл нэр өмнө бидний тэмдэглэснээр *Өлзийт, Баян, Өгөөмор* зэрэг газар нутгийн нэртэй адил үүрэг гүйцэтгэнэ. Тийнхүү “хайрхан” нэр газар нутгийн нэрэнд хоёрдмол үүрэгтэй бол үүнийг “тахилга” нэрийн хувьд бүр ч тодорхой юм. “Тахилга”, “тахилгат” нь зөвхөн цээрлэсэн нэрийг орлох үүрэгтэй. Эдгээр нэрийн зүйлийг авч үзье. Үүнд:

Тахилга:

Тахилга ам (Архангайн Хашаат), Тахилгат ам (Дорнодын Матад, Баянхонгорын Баянцагаан, Увсын Цагаанхайрхан, Өвөрхангайн Зүүнбаян-Улаан, Бага Тахилга

уул (Өвөрхангайн Гучин-Ус), Бага Тахилгат уул (Сүхбаатарын Мөнххаан), Баруун Тахилга уул (Төв аймгийн Сүмбэр), Баруун Тахилгат уул (Дундговийн Адаацаг), Баянгийн Тахилгат уул (Төв аймгийн Эрдэнэсант), Долоон Тахилга уул (Төв аймгийн Дэлгэрхаан), Зузаан Тахилгат уул (Төв аймгийн Алтанбулаг), Зүүн Тахилга уул (Төв аймгийн Сүмбэр), Зүүн Тахилгат уул (Дундговийн Адаацаг), Их Тахилга уул (Өвөрхангайн Хайрхандулаан, Нарийнтээл, Өмнөговийн Ханхонгор, Баянхонгорын Өлзийт, Сүхбаатарын Мөнххаан), Тахилга Овоот уул (Дундговийн Өлзийт), Тахилга Овоот уул (Дундговийн Хулд, Дундговийн Луус), Тахилга Хайрхан уул (Баянхонгорын Заг), Тахилга уул (Дундговийн Өлзийт, Төв аймгийн Баян-Өнжүүл, Өвөрхангайн Тарагт, Өвөрхангайн Өлзийт, Нарийнтээл, Зүүнбаян-Улаан, Сэлэнгийн Мандал, Өмнөговийн Хүрмэн, Ноён, Ханхонгор, Баянхонгорын Баянлиг, Бөмбөгөр, Ховдын Үенч, Хэнтийн Мөрөн, Хэрлэн, Өмнөдэлгэр, Баянхонгорын Өлзийт), Тахилган уул (Өмнөговийн Сэврэй), Тахилгат Байц уул (Хөвсгөлийн Рэнчинлхүмбэ), Тахилгат Овоо уул (Говь-Алтайн Тайшир), Тахилгат Овоот уул (Баянхонгорын Баянцагаан), Тахилгат Хар Өндөр уул (Өмнөговийн Хүрмэн), Тахилгат Хүрэн уул (Дорноговийн Хатанбулаг), Тахилгат Цагаан уул (Дундговийн Өлзийт), Тахилгат Цагаан уул (Дорноговийн Даланжаргалан), Тахилгат уул (Увсын Давст, Дундговийн Дэлгэрхангай, Архангайн Эрдэнэмандал, Дундговийн Сайхан-Овоо, Дундговийн Адаацаг, Өвөрхангайн Зүүнбаян-Улаан, Өвөрхангайн Төгрөг, Богд, Төв аймгийн Баян, Эрдэнэ, Завханы Цагаанхайрхан, Хөвсгөлийн Тосонцэнгэл, Түнэл, Улаан-Уул, Сэлэнгийн Сант, Говь-Алтайн Дарви, Баян-Өлгийн Цэнгэл, Дорнодын Дашбалбар, Сүхбаатарын Сүхбаатар, Баянхонгорын Баянцагаан, Өмнөговийн Номгон, Мандал-Овоо, Ханбогд, Гурвантэс, Увсын Цагаанхайрхан, Хэнтийн Галшир, Дархан, Говь-Алтайн Цээл, Дорноговийн Айраг, Баянхонгорын Шинэжинст, Заг), Тахилгатын Ухаа Овоо уул (Дундговийн Дэрэн), Үзүүр Тахилга уул (Өмнөговийн Ханхонгор), Хайластайн Тахилгат уул (Дундговийн Дэлгэрхангай), Хармагтайн Тахилга уул (Дундговийн Гурвансайхан), Хөшөөтийн Тахилга уул (Төв аймгийн Дэлгэрхаан), Тахилгатын ухаа (Хэнтийн Галшир), Тахилгатын хавцал (Говь-Алтайн Алтай), Тахилгатын хоолой (Хэнтийн Галшир), Тахилгатын хөндий (Өмнөговийн Сэврэй), Тахилга худаг (Өмнөговийн Ноён), Дундговийн Дэлгэрхангай), Тахилгат худаг (Төв аймгийн Баяндэлгэр), Тахилгатын худаг (Хэнтийн Мөрөн), Тахилгатын хуруу (Говь-Алтайн Чандмань), Тахилгат хяр (Баян-Өлгийн Улаанхус), Тахилгатын хяр (Өвөрхангайн Зүүнбаян-Улаан, Өмнөговийн Баян-Овоо), Адагийн Тахилга хясаа (Увсын Тариалан), Дунд Тахилга хясаа (Увсын Тариалан), Тахилгатын Хошуу цав (Дорноговийн Хатанбулаг), Тахилгат цохио (Архангайн Хайрхан), Тахилгант булаг (Хөвсгөлийн Тосонцэнгэл), Тахилгат булаг (Увсын Сагил, Дорнодын Сэргэлэн, Баянхонгорын Баянцагаан, Хөвсгөлийн Тосонцэнгэл, Тариалан), Тахилгат Ногоон Хөвийн булаг (Өмнөговийн Номгон), Тахилгатын булаг (Хэнтийн Дархан), Тахилга гол (Баян-Өлгийн Цэнгэл), Тахилгант гол (Хөвсгөлийн Тосонцэнгэл), Тахилгат гол (Хөвсгөлийн Рэнчинлхүмбэ, Ховдын Цэцэг), Тахилгатын гол (Говь-Алтайн Шарга), Тахилгатын нуруу (Ховдын Цэцэг, Төв аймгийн Сэргэлэн), Асмарын Тахилгат овоо (Сүхбаатарын Мөнххаан), Билүүний Тахилга овоо (Өмнөговийн Цогт-Овоо), Тахилга овоо (Ховдын Үенч), Тахилгат овоо (Өвөрхангайн Богд, Говь-Алтайн Тайшир), Тахилгатын огтрого (Баянхонгорын Баянцагаан), Бага Тахилга сайр (Өвөрхангайн Хайрхандулаан), Тахилгат сайр (Дундговийн Өлзийт), Тахилгатын сайр

(Баянхонгорын Баянлиг), Тахилгат тойром (Дундговийн Сайхан-Овоо, Дорноговийн Мандах), Тахилгат толгод (Баянхонгорын Бууцагаан), Адааг Тахилга толгой (Увсын Тариалан), Бага Тахилгат толгой (Дорноговийн Иххэт), Баянгийн Тахилгат толгой (Өмнөговийн Ханхонгор), Дунд Тахилга толгой (Увсын Тариалан), Зүүн Тахилгат толгой (Дундговийн Говь-Угтаал), Их Тахилгат толгой (Дундговийн Луус), Мөнхийн Тахилгат толгой (Дундговийн Сайнцагаан, Луус), Нарангийн Тахилга толгой (Дундговийн Гурвансайхан), Тахилга толгой (Булганы Баян-Агт, Дундговийн Говь-Угтаал, Увсын Малчин, Баянхонгорын Өлзийт, Тахилга толгой (Хэнтийн Баянхутаг, Өвөрхангайн Уянга, Төв аймгийн Жаргалант, Өвөрхангайн Хужирт, Төв аймгийн Сүмбэр, Баян-Өнжүүл, Хэнтийн Дадал), Тахилгат Овоот толгой (Дундговийн Өлзийт), Тахилгат Овоо толгой (Өвөрхангайн Төгрөг), Тахилгат Улаан Хөшүүр толгой (Увсын Сагил), Тахилгат Улаан толгой (Дорноговийн Мандах), Тахилгат Цагаан толгой (Дундговийн Дэлгэрхангай), Тахилгат толгой (Завханы Отгон, Булганы Хишиг-Өндөр, Хангал, Завханы Шилүүстэй, Дундговийн Дэрэн, Луус, Адаацаг, Гурвансайхан, Говь-Угтаал, Дорноговийн Даланжаргалан, Завханы Баянтэс, Ховдын Эрдэнэбүрэн, Дорноговийн Сайхандулаан, Иххэт, Эрдэнэ, Өмнөговийн Цогт-Овоо, Номгон, Манлай, Баянхонгорын Бууцагаан, Хэнтийн Баянхутаг, Дорнодын Чулуунхороот, Дорнодын Сэргэлэн, Өмнөговийн Баян-Овоо, Сүхбаатарын Түвшинширээ, Мөнххаан, Сүхбаатар, Баян-Өлгийн Улаанхус, Дундговийн Өлзийт, Сайхан-Овоо, Сайнцагаан, Өлзийт, Төв аймгийн Баянцагаан, Хөвсгөлийн Тариалан, Цагаан-Уул, Шинэ-Идэр, Хэнтийн Норовлин), Тахилгатын Баян толгой (Говь-Алтайн Чандмань), Тахилгатын Улаан толгой (Хөвсгөлийн Тосонцэнгэл), Тахилгатын Хар толгой (Өмнөговийн Баян-Овоо), Тээлийн Тахилга толгой (Өвөрхангайн Хужирт), Ховоотын Тахилгат толгой (Өмнөговийн Ханхонгор), Цагаан Тахилгат толгой (Дундговийн Луус), Эхэн Тахилга толгой (Увсын Тариалан), Тахилгатын Доод тохой (Завханы Цагаанхайрхан), Тахилгатын Дээд тохой (Завханы Цагаанхайрхан), Тахилга Усан сан (Говь-Алтайн Алтай) зэрэг болно.

“Тахилга”, “Тахилгат” нэр тольд нийт 202 нэрэнд оржээ. Эл тоо тахилгатай газар нутгийн нэр цээрлэх шалтгаанаар түүнийг орлон хэлэгдэх болсон нь маргаангүй. Дээрх нэрийн цэсээс газар нутгийн нэрэнд шашны үзэл, хүмүүсийн сүсэг бишрэл нөлөөлсөн дүр зураг тов тодорхой харагдаж байна.

Өмнө өгүүлснээс бөөгийн болон бурхны шашны үзэл Монголын газар нутгийн нэрэнд үлэмж тусчээ. Тэрхүү нөлөөг эерэг, сөрөг хоёр талаас нь үнэлж болно. Эерэг нь монголчууд олон зууны турш нутаг усаа унаган төрхөөр нь үр хойчдоо өвлүүлэн үлдээхэд чухал хүчин зүйл болжээ. Сөрөг нь байгалийн биетийн цөөнгүй уугуул монгол нэр мартагдсан байна.